

## Хүснэгт 1.1 Байгаль орчны менежментийн хөтөлбөр

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
<b>P-1 : Барилгын ажлын өмнөх үе шат</b>					
Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний хамгаалалт	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын талбарт орсон зайлуулах шаардлагатай дэд бүтэц /Цахилгаан шон, ус дамжуулах хоолой гэх мэт/-г холбогдох байгууллагуудын урьдчилсан зөвшөөрлийг үндэслэн нүүлгэн шилжүүлэх.</li> <li>Төслийн аль ч бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд барилгын ажил эхлэхээс өмнө нүүлгэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажил эхлэхээс өмнө	ТХН/ Инженер	ТХН/ Инженер
<b>M-1: Гүйцэтгэчийг талбайд байршуулах ба талбайн цэвэрлэгээ</b>					
Талбайн цэвэрлэгээ	<ul style="list-style-type: none"> <li>Талбайн цэвэрлэгээний үеэр нийтийн болон хувийн эд хөрөнгийг эвдэж гэмтээхгүй байхад анхаарч бүх шаардлагатай алхамуудыг хийнэ.</li> <li>Хэрвээ ийм хохирол гарвал, эдгээрээс үүсэх үр дагаварыг гүйцэтгэгч бүрэн хариуцна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Талбайн цэвэрлэгээний үеэр	Гүйцэтгэгч	ТХН/ Инженер
Ажиллагсдын барилгын талбайн түр байр	<ul style="list-style-type: none"> <li>Талбайн түр байрыг оршин суугчдын амьдрах орчноос 500м-ээс багагүй зайд байрлуулна.</li> <li>Түр байр, туслах байгууламжийг инженерийн баталсан стандарт, хэмжээсийн дагуу барьж, ашиглана.</li> <li>Асфальтын ба бутлуурын завод, материал холих газруудын ойролцоо бие засах газар, жорлонгуудыг байгуулна.</li> <li>Талбайн түр байрын хашаанд хогийн савуудыг байрлуулан тогтмол хоосолж хогийг эрүүл ахуйн шаардлага хангасан байдлаар зайлуулна.</li> <li>Барилгын ажлын түр байр, үйлдвэрийн газруудад уснаас үүсэлтэй өвчин гарахаас сэргийлэх үүднээс хангалттай хэжээний сайн чанарын усыг нөөцлөн хадгалж, ажилчдын эрүүл мэнд, ариун цэврийн талаар анхаарна.</li> <li>Газрын хөрс, усны эх үүсвэр, худаг зэргийг бохирдуулахгүй байх үүднээс барилгын ажилчдын түр байранд бохир зайлуулах системийг (бохирын сав, бохир усны нүх г.м.) төлөвлөж, байгуулж, ашиглана.</li> </ul>	Барилгын түр байр	Барилгын ажил эхлэхээс өмнө	Гүйцэтгэгч	ТХН/ Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
Усны хангамжийн зохицуулалт	<ul style="list-style-type: none"> <li>Усны хүртээмж, ойр орчмын оршин суугчдын хангамжид нөлөөлөхгүй байхаар барилгын ажлын усны шаардлагыг бие даасан байдлаар зохицуулна.</li> </ul>	Барилгын түр байр	Барилгын ажил эхлэхээс өмнө	Гүйцэтгэгч	ТХН/ Инженер
Бохирын цэгүүдийг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> <li>Инженер нь дараах зүйлсүүдийг баталгаажуулж, бохирын цэгүүдийн байршлыг эцэслэн тогтооно: (а) Байршил нь ойн бүсэд оршихгүй, (б) Бохир нь байгалийн усны урсацад нөлөөлөхгүй, (в) Бохир нь ховордсон/ховор ургамалд нөлөөлөхгүй, (г) Байршил нь суурин газруудаас 500м-ээс багагүй зайд байрлана.</li> </ul>	Барилгын түр байр	Барилгын ажил эхлэхээс өмнө	Гүйцэтгэгч	ТХН/ Инженер
Гал гарсан үед авах хариу арга хэмжээний бэлтгэл	<ul style="list-style-type: none"> <li>Гал гарсан үед авах хариу арга хэмжээний бэлтгэлд дараах зүйлс орно:</li> <li>Гал түймэр унтраах зохих тоног төхөөрөмжийг ажлын байран дахь гал түймрээс урьдчилан сэргийлэх дүрмийн шаардлагын дагуу барилгын талбар дээр хадгална.</li> <li>Гал түймэр унтраах тоног төхөөрөмж нь стандартын шаардлагыг хангаж байх бөгөөд барилгын ажлын бүх үе шатны турш сайтар шалгана.</li> <li>Шаардлагатай үед ажлын байран дахь гал түймрээс урьдчилан сэргийлэх дүрмийн дагуу барилгын хүнд болон хөнгөн машин механизм, усны машин, тээврийн хэрэгслийг гал унтраах зорилгоор бэлэн байлгана. Мөн шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлтгэнэ. (жишээлбэл, усны цүнх, тармуурын зээтүү, гал унтраагч гэх мэт) тоноглоно.</li> </ul>	Барилгын түр байр	Барилгын ажил эхлэхээс өмнө	Гүйцэтгэгч	ТХН/ Инженер
Халуун холимог, зуурмагийн үйлдвэр байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>Халуун холимог, зуурмагийн үйлдвэрүүдийг иргэдийн амьдрах орчноос хангалттай зайтай байрлуулна. Хэрэв боломжтой бол иргэдийн амьдрах орчноос 1000м-ээс багагүй зайд байрлуулна.</li> </ul>	Барилгын түр байр	Барилгын ажил эхлэхээс өмнө	Гүйцэтгэгч	ТХН/ Инженер
<b>С-1: Барилгын ажлын үе шат (Бодит хүрээлэн буй орчин)</b>					
Ариун цэвэр ба эрүүл ахуйн асуудал	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын талбайг цэвэр, тохилог нөхцөлд байлгана. Бүх гарсан хог, хаягдлыг сайтар цэвэрлэнэ.</li> <li>Хүн, амьтны эрүүл мэнд болон ургамал зэрэгт хортой, тэднийг гэмтээх магадлалтай хориотой материалыг ашиглах,</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
	тэдгээрийг үйлдвэрлэх зэргийг үл зөвшөөрнө. Хэрвээ тийм материалаас зайлсхийх боломжгүй бол ажилчдыг хамгаалалтын хувцас хэрэгслээр хангана.				
Уур амьсгалд үзүүлэх нөлөө	<ul style="list-style-type: none"> <li>Уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөө нь зөвхөн хэсэгчилсэн, түр зуурын шинж чанартай байх болно. Төслийн хэрэгжих бүсэд салхины төлөв, температур, хур тундас өөрчлөгдөхгүй. Иймд дээрх нөлөөллийг бууруулах тодорхой арга хэмжээг санал болгохгүй байна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Газрын тогтворжилт, байр зүйд үзүүлэх нөлөө	<ul style="list-style-type: none"> <li>Газрын гадарга, тогтворжилтод ноцтой нөлөө үзүүлэхгүй.</li> <li>Хөрсний овоолгыг нарийн нягт байрлуулж, урсацын суваг болон усны сав барьж, замын чиглэлийг зөв байгуулснаар барилгын ажлын явцад үүсэх хүндрэлүүдийг ихээхэн бууруулна. Гэсэн хэдий ч хөрс тэгшлэх, газар ухах болон бусад барилгын үйлчилгээ хийх явцад газрын гадарга, тогтворжилтод нөлөөлж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд зохих хэмжээний нөлөөллийг бууруулах арга хэмжээг авахыг зөвлөж байна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
<b>С-2: Барилгын ажлын үе шат (Байгаль орчны чанарт үзүүлэх нөлөө)</b>					
Усны чанар	<ul style="list-style-type: none"> <li>Төсөл хэрэгжих газрын гадаргуун болон хөрсний усны чанарыг хадгалах зорилгоор нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг авна. Үүнд:</li> <li>Гадаргын усыг бохирдохоос сэргийлэх: Зам, ус зайлуулах байгууламж, халуун усны байрны барилгын ажлын үед үүсэх урсацыг тогтоон барих болон цэвэрлэх түр зуурын нүх ухах арга хэмжээнүүдийг төлөвлөх. Барилгын ажил дууссаны дараа нүхнүүдийг шороогоор буцааж булан урьдын хэвэнд оруулан тэгшилж засна.</li> <li>Усны урсацыг тогтоож хаалт хийх зорилгоор босоо шуудуу барихаас зайлсхийх.</li> <li>Зам/явган хүний зам/далан шуудууг сайжруулах ажлын үед шатахуун түгээх станц болон автомашины засварын газрыг ойролцоох далан суваг/усны эх үүсвэрээс дор хаяж 300 м зайтай байхаар төлөвлөнө. Шатахууныг зориулалтын хадгалах саванд байлгах нь зүйтэй. Зарим газруудад уг савнуудыг хадгалах зорилгоор мөн машин угаалга,</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар/ барилгын ажлын машин, механизмыг байрлуулах газар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
	<p>засварт зориулан бензин тос нэвтэрч шүүрэх болон үсэрч цацагдахаас сэргийлэх үүднээс асфальт хүчилт хийнэ. Эдгээр газруудыг тодорхой хугацаанд цэвэрлэж байна. Бүх цуглуулсан хог хаягдлыг хотын хогийн цэг руу машинаар зөөвөрлөнө.</p> <ul style="list-style-type: none"> <li>Автомашины зогсоол, засварын газар барих үед тос тосоол асгарч алдагдаж болзошгүй. Хаягдал усыг зайлуулахаас өмнө шүүх зорилгоор тос шүүгчээр тоноглоно.</li> </ul>				
Агаарын чанар	<p>Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь ашиглалтын үеээс илүү барилгын үе шатанд илүү илэрнэ. Дараах нөлөөллийг бууруулах арга хэмжээг санал болгож байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>Барилгын тоног төхөөрөмж, машин механизмаас ялгарах хорт утааг тогтоосон стандартад нийцүүлэн ашиглана.</li> <li>Хэт их хорт утаа ялгаруулдаг машин механизм (утааны үүл харагдах)-ыг барилгын талбайд ашиглахыг хориглоно.</li> <li>Асфальт болон бетон зуурмагийн үйлдвэрийг “Агаарын тухай хууль”-ийн дагуу ажиллуулна.</li> <li>Тээврийн хэрэгслийн ашиглалтанд тогтоосон стандартыг мөрдөнө.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Галын аюулгүй байдал	<p>Галын аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>Галын аюул өндөр байх үед гал гарах эрсдэлтэй газарт барилгын ажлыг зогсооно</li> <li>Ажлын байран дахь гал түймрээс урьдчилан сэргийлэх дүрмийн дагуу гал авалцах боломжтой зүйл болон галын аюул учруулж болзошгүй тоног төхөөрөмжийн ойр орчмоос бүх шатамхай материалыг зайлуулна</li> <li>Бүх машин механизмын засвар үйлчилгээ, ашиглалт нь галын аюулгүй байдлын холбогдох стандартыг дагаж мөрдөнө.</li> <li>Ашиглагдаагүй машин механизм, автомашиныг шатамхай материалгүй зориулалтын талбайд байрлуулна</li> <li>Галын эрсдэлийг бууруулахын тулд шатамхай материалыг тогтмол хянаж зохицуулна</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
Тоосжилт үүсэх	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын материал зам дээр унахаас сэргийлэх үүднээс тэдгээрийг тээвэрлэх явцад бүтээх арга хэмжээ авах</li> <li>Гүйцэтгэгч, халуунаар холих болон орцлох үйлдвэрүүдээс гарах тоосжилтын төвшинг Инженерийн тавьсан шаардлагыг хангах хэмжээнд багасгах үүднээс шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах</li> <li>Хог шороог гараар шүүрдэх эсвэл Инженер зөвшөөрсөн тохиолдолд механик шүүр болон цэвэрлэх төхөөрөмжөөр хаягдлыг тэр дор нь цэвэрлэх, Мөн, Инженерийн зөвшөөрлөөр шаардлагатай тоног төхөөрөмжийг ашиглан тоос шороо босохоос сэргийлж тогтмол хугацаанд усалж байх.</li> <li>Үйлдвэр, завод, тоног төхөөрөмжүүдийг тоосжилтыг багасгах зорилгоор шаардагдах бүх арга хэмжээг авч (хуулах гэх мэт) ажиллана.</li> </ul>	Төслийн туршид	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Халуун холимог болон зуурмагийн үйлдвэрүүдээс ялгарах утаа	<ul style="list-style-type: none"> <li>Яндангийн хий нь агаарын бохирдлын тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хангах ёстой.</li> <li>Үйлдвэрийн бүх үйл ажиллагааг байгаль орчны тухай бүх хууль тогтоомж, дүрмийн дагуу явуулна.</li> </ul>	Төслийн туршид	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Барилгын ажлын машин тэрэг, тоног төхөөрөмж, механизмаас гарах утаа	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын ажилд ашиглах бүх машин механизм, тоног төхөөрөмжид тогтмол засвар арчилгаа хийн бохирдлын хэмжээг стандартын хэмжээнд байлгах</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Бутлуураас гарах тоосны бохирдол	<ul style="list-style-type: none"> <li>Бутлуураас ялгарах тоосжилт (ялгарсан нарийн тоосонцор) нь тогтоосон стандартад нийцэх ёстой.</li> <li>Тусгаарлагдсан цэг болон кластер дотор байрлах цэгээс 40м зайд хэмжсэн тоосжилт (ялгарсан нарийн тоосонцор)-ийн хэмжээ 500 мкг/м<sup>3</sup>-аас бага байна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Дуу чимээ	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын машин механизмыг суурин газраас хол байрлуулна.</li> <li>Машин механизмын ажиллагааг сайтар төлөвлөж, цагийн хуваарь гаргах нь дуу чимээний түвшинг бууруулна. Найман цагийн ээлжээр</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
	<p>ажиллах барилгын талбайг иргэдийн оршин суух газраас 1км-ээс доошгүй зайд байршуулж, 90 дБ (А)-ээс ихгүй дуу чимээ гаргадаг тоног төхөөрөмж ашиглана.</p> <ul style="list-style-type: none"> <li>Барилгын ажлын явцад машин механизмын дуу чимээнээс хамгаалах хэрэгсэл ашиглаж, хүнд машин механизмын операторуудыг чихний бөглөөгөөр хангах нь дуу чимээний нөлөөллийг бууруулна.</li> <li>Барилгын бүх тоног төхөөрөмж, машин механизм, үйлдвэр, тээврийн хэрэгсэл нь дуу чимээний стандартыг дагаж мөрдөнө. Найман цагийн ээлжинд ашиглагдах барилгын бүх тоног төхөөрөмжүүд стандартын дагуу 90 дБ (А)-ээс их дуу чимээ гаргахгүй.</li> <li>Хот суурин газраас 150м-ийн зайд байрлах барилгын талбайд 22:00 цагаас 06:00 цагийн хооронд дуу чимээ ихтэй ажил гүйцэтгэхгүй.</li> <li>Дуу чимээг хамгийн бага хэмжээнд байлгахын тулд барилгын машин механизм, тээврийн хэрэгслүүдийн дуу намсгагчийг тогтмол хянах.</li> <li>Их дуу чимээний ойролцоох ажилчид чихний бөглөө, хамгаалалтын малгайг тогтмол өмсөх бөгөөд үргэлжилсэн хугацаанд 90 дБ (А)-ээс дээш дуу чимээний хажууд байхаас урьдчилан сэргийлж ээлжээр солигдож байх ёстой.</li> <li>Эмнэлэг, сургууль гэх мэт чухал объектуудын дэргэд ажиллах тохиолдолд мод эсвэл цайрдсан төмөр хавтан ашиглаж түр зуурын дуу чимээ тусгаарлагч хана босгоно.</li> <li>Барилгын ажлуудын хурдыг багасгах, тээврийн хэрэгслийн тоо, ажиллах хугацааг хязгаарлах зэрэг нь дуу чимээг бууруулна.</li> </ul>				
Барилгын тоног төхөөрөмжөөс үүсэх дуу чимээ	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын ажилд хэрэглэгдэх үйлдвэр, завод, тоног төхөөрөмж (чулуу бутлах үйлдвэр) нь дуу чимээний стандартын шаардлагыг хангана.</li> <li>Барилгын ажилд хэрэглэх бүх машин, тоног төхөөрөмжийг дуу намсгагчаар тоноглоно.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
	<ul style="list-style-type: none"> <li>Байнгын засвар арчлалтын үйлчилгээний үед, дуу намсгагчийн ашиглалтын байдлыг шалгаж, хэрвээ доголдолтой бол шинээр сольж тавина.</li> <li>Гэрээний бусад нөхцөлүүдийг үл харгалзан, үйлдвэр(үүд)ийн аль нэг сэлбэг, хэрэгслээс гарч буй дуу чимээний төвшин нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан байна.</li> <li>Энэ төсөлд (тоног төхөөрөмжийн ирмэгээс нэг метрийн зайнд хэмжиж үзэхэд) ашиглагдах нягтруулагч, индүү, ачигч, бетон холигч, кран (явдаг), доргиулагч, хөрөө гэх мэт тоног төхөөрөмжийн дуу чимээний тогтоосон хязгаар 75 децибал (А)-аас хэтрэх ёсгүй.</li> <li>Машин механизм, тоног төхөөрөмжийн засвар арчлалтыг тогтмол Инженерийн шаардлага хангах хэмжээнд хийж, тэдгээрээс гарах дуу чимээг хамгийн бага тогтоогдсон хэмжээнд байлгана.</li> <li>Дуу чимээ ихтэй хэсэг болон бутлуур, нягтруулагч, бетон зуурагч дээр ажиллаж буй ажилчид чихэвч зүүнэ.</li> </ul>				
Усан хангамжийн системийн ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>Усан хангамжийг тасалдуулахгүйн тулд усан хангамжийн системд сайжруулалт хийх явцад болгоомжтой байх хэрэгтэй.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
<b>С-3: Барилгын ажлын үе шат</b> (Экологийн нөөцөд үзүүлэх нөлөө)					
Мод	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын ажлын үед барилгын ажилчид мод, ургамлыг түлшинд хэрэглэснээр модны хэмжээ багасаж болох юм. Иймээс барилгын ажилчдад хийн түлш, цахилгаан зэрэг бусад хувилбарт түлшээр хангах замаар нөлөөллийг бууруулж болно.</li> <li>Мод огтлох нь хүрээлэн байгаа орчинд хэрхэн нөлөөлдөг талаар байгаль орчны боловсролын сургалтыг барилгын ажилчдад олгоно.</li> <li>Ургамалд нөлөөлөх тоосны бохирдлыг багасгахын тулд барилгын ачаа тээврийн хэрэгслүүд дээр ус цацаж, чийгшүүлнэ.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбарын ойр орчинд	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
<b>С-4: Барилгын ажлын үе шат</b> (Хүний хэрэглээний үнэт зүйлд үзүүлэх нөлөө)					
Хөшөө дурсгалууд/Түүхийн дурсгалт газар	Оролцогч талуудтай хийсэн хэлэлцүүлэг болон бусад судалгааг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийг археологийн сонирхолт газар биш бөгөөд археологийн дурсгалт зүйл байхгүй болохыг тогтооно.	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
	<ul style="list-style-type: none"> <li>Сүм хийдэд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах бүх шаардлагатай арга хэмжээг авна.</li> <li>Тухайн газраас олдсон аливаа гэнэтийн олдвор нь Засгийн газрын өмч байх бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.</li> <li>Гүйцэтгэгч нь өөрийн ажилчид болон бусад хүмүүс гэнэтийн олдворыг устгах, гэмтээхээс урьдчилан сэрхийлэх арга хэмжээ авна. Гэнэтийн олдворыг олж илрүүлсэн даруйд Инженерт танилцуулж, Инженерийн зааврыг дагах ба тухайн газраас 100 метрийн зайд хийгдэж буй бүх ажлыг зогсооно.</li> </ul>				
Барилгын ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй	<ul style="list-style-type: none"> <li>Зам, явган хүний зам, далан суваг, ус хангамжийн шугам сүлжээг барьж байгуулахад хог хаягдал зайлшгүй гарна. Гэхдээ жирийн нөхцөлд хогийн хэмжээ харьцангуй бага байна. Харийн зам/явган хүний зам барих үед хөрс хуулж зайлуулах учраас гарах хогийн хэмжээ жирийн үеийнхээс их байна.</li> <li>Гүйцэтгэгч нь барилгын талбайд хяналт тавьж, түүнийг цэвэр цэмцгэр байлгах, гарч байгаа хогийн зайлуулах хүртэл хогийг байр саванд түр хадгалах ажлыг хариуцна.</li> <li>Барилгын хог хаягдлыг тусгай хогийн талбайд хадгална. Ийм хогийг хадгалахдаа ус хангамж, усны эх үүсвэрийг бохирдохоос хамгаалж, мөн хуурай улиралд шороо тоос босохоос хамгаалах арга хэмжээ авна.</li> <li>Гүйцэтгэгч нь байгаль орчныг бохирдуулах, хүн, амьтанд хортой нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх үүднээс бүх хогийг болгоомжтой тээвэрлэх, хадгалах үүргийг хүлээнэ.</li> <li>Барилгын талбайд ажиллах бүх хүмүүсийн хөдөлмөр хамгаалал, ая тухтай байдал, эрүүл мэндийг баталгаажуулах, аюулгүй орчинд үр дүнтэй ажиллах нөхцөл хангахад шаардлагатай урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авна.</li> <li>Барилгын талбайд аюултай байрлалд ажиллаж байгаа ажилчид хамгаалалтын малгай, зориулалтын гутал өмсөнө. Барилгын талбайд ажиллаж байгаа бүх ажилчид нь нүдний хамгаалалтын шил,</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер



Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
	<p>сонсголын хамгаалалт, хамгаалалтын малгай зэрэг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл өмсөнө.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гал унтраагч болон анхны тусламжийн төхөөрөмжүүдийг барилгын талбайд байлгана.</li> <li>• Барилгын талбайд бэртэл гэмтэл гарч болзошгүй. Иймээс барилгын бүх ажилчдад зориулсан эмнэлгийн анхны тусламжийн төхөөрөмжийг заавал байлгана. Барилгын талбай болон бүх ажлын байранд эмнэлгийн анхны тусламжийн төхөөрөмж, сувилагчийг байлгана.</li> <li>• Гүйцэтгэгч нь угсралтын бүх ажилд зөвхөн мэргэшсэн, чадварлаг ажилчдыг ашиглана.</li> <li>• Санамсаргүй гэмтлээс үүдэх онцгой нөхцөл байдлыг илрүүлэх/шийдвэрлэх талаар ажилтнуудад сургалт явуулна.</li> <li>• Аюулгүй ажиллагааны арга хэмжээ, ажлын горимыг газар дээр нь хэрэгжүүлнэ. Ажилчид аюултай нөхцөлд ажиллахаас татгалзах эрхтэй болно.</li> <li>• Гүйцэтгэгч нь осол аваараас урьдчилан сэргийлэх үүднээс ажлын байран дахь аюулгүй ажиллагааны журмыг боловсруулж, мөрдүүлэх ёстой.</li> <li>• Гүйцэтгэгч нь ХАБ-ын үйл ажиллагааны стандарт, зааврыг боловсруулж мөрдүүлнэ.</li> <li>• Гүйцэтгэгч нь ажилчдад эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар мэдлэг мэдээлэл олгоно.</li> <li>• Гүйцэтгэгч нь ажилтнуудад гал түймэр/тэсэлгээний үед авах арга хэмжээний талаар сургалт явуулна.</li> <li>• Гүйцэтгэгч нь ажилчдыг гэмтээхээс урьдчилан сэргийлэхийн тулд барилгын бүх тоног төхөөрөмжийг аюулгүй ажиллагааны нөхцөлд байлгана.</li> </ul>				
Усан хангамжийн системд цасны нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> <li>• Усан хангамжийн системд цасны нөлөөллийг хянаж, усан хангамжийн тогтвортой байдлыг хангах үүднээс ус дамжуулах хоолойг 2.5 метр гүнд байрлуулах, боломжгүй тохиолдолд хоолойг термоскопоор хамгаалах арга хэмжээ авна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
<b>С.5 Барилгын ажлын үе шат</b> (Бусад нөлөөллүүд)					
Ариун цэвэр ба хог хаягдлыг зайлуулах	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын талбайд зөөврийн жорлон байрлуулна.</li> <li>УСУГ-ын болон хувийн хэвшлийн бохирын машинүүдээр бохирыг зайлуулж, сүлтгаж байна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Хөдөлгөөний саатал ба хэт ачаалал	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлгөөний хяналтын нарийвчилсан хөтөлбөрийг гарган зам, далан суваг, үс хангамжийн шугам сүлжээний ажил эхлэхээс 5 хоногийн өмнө инженерээр батлуулна.</li> <li>Өдөр бүр ажил дууссаны дараа хөдөлгөөнийг зохицуулах болон барилгын ажлын арга хэмжээнүүдийг нарийвчлан тусгасан хөдөлгөөний хяналтын төлөвлөгөө.</li> <li>Явах гадаргын нөхцөл байдлыг байнгын сайн нөхцөлтэй байлгаж, ялангуяа борооны улиралд хөдөлгөөний саатал гаргахгүй байхаар Гүйцэтгэгч зохицуулна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Ашиглалтын үед гарах эрсдэл	<ul style="list-style-type: none"> <li>Гүйцэтгэгч хөдөлмөр хамгааллын шаардлагатай хэрэгсэл болох хамгаалалтын нүдний шил, малгай, маск зэргээр ажилтан албан хаагчдаа хангана.</li> <li>Хамгаалалтын тавцан, шат, ажлын тавцан, дамнуурга шат, өгсдөг шат, сүүрийн нүх, суваг шуудуу, орох, гарах аюулгүйн гарц зэргийг Гүйцэтгэгч аюулгүйн ажиллагааны журам зааврын дагуу бэлтгэнэ.</li> <li>Төслийн ажилд хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүй.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбарын ойр орчинд	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Аюултай үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүд	<ul style="list-style-type: none"> <li>Асфальтын материал зуурах, шохойн уусмал, цементтэй ажилладаг бүх ажилчдад хамгаалалтын гутал, нүдний шилээр хангана.</li> <li>Гагнуур хийдэг ажилчдад гагнуурын хамгаалалтын нүдний шилээр хангана. Чулуу буталдаг хүмүүст хамгаалалтын нүдний шил хувцсаар хангах бөгөөд түүнийг аюулгүй байрлалд байрлуулна.</li> <li>Гербицид, эсвэл хортой химийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврыг хатуу баримтлан ашиглана.</li> <li>Аливаа гербицид болон химийн хорт бодисыг ашиглахаар төлөвлөж байгаа тухай мэдэгдлийг 6 хоногийн өмнө инженерт өгнө.</li> </ul>	Барилгын тоног төхөөрөмж, материал хадгалах газар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
	<ul style="list-style-type: none"> <li>Бүх гербицид, химийн бусад хорт бодисын бүртгэлийг Гүйцэтгэгчид хадгалуулж, шинэчилж байх зорилгоор барилгын талбайд хүргүүлнэ.</li> <li>Бүртгэлд худалдааны нэр, бодит хөрөнгө, шинж чанар, химийн бүтэц, эрүүл ахуй, хадгалалтын журам болон бүтээгдэхүүний анхны тусламжийн заавар зэргийг багтаана.</li> </ul>				
Гамшгийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> <li>Инженерийн өгсөн гамшгийн эрсдэлийн эсрэг бүх зааврыг Гүйцэтгэгч нь өөрийн зардлаараа дагаж мөрдөнө.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Анхны тусламж	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын байр бүрт ариутгасан боолтын материал, багаж хэрэгсэл зэрэг анхны тусламжийн хэрэгсэлийг байнга бэлэн байлгана.</li> <li>Гэмтэж бэртсэн болон өвчтэй хүнийг (хүмүүсийг) ойр байрлах эмнэлэгт хүргэхэд тохиромжтой тээврийн хэрэгслээр хангана.</li> <li>Ажлын байр бүрт эсвэл барилгын талбайд эмнэлгийн туслах ажилтан байна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
<b>О-1: Ашиглалтын үе</b>					
Ойролцоох гол мөрөнгийн усны чанар доройтох	<ul style="list-style-type: none"> <li>Төлөвлөж буй ажлуудаас шалтгаалан усны чанарыг доройтуулахгүйн тулд хяналт -шинжилгээний төлөвлөгөөнд заасны дагуу Туул голын цутгал голуудын усны чанарт үе үе хяналт тавьж ажиллана.</li> </ul>	УСУГ	Барилгыг хүлээлгэн өгсний дараа		
Ус зайлуулах сувгийн зохисгүй менежментээс үүдсэн хөрс, усны нөөцийн бохирдол	<ul style="list-style-type: none"> <li>НЗДТГ -аас ус зайлуулах бүх шугамыг үе үе цэвэрлэх бөгөөд ингэснээр ус зайлуулах шугам дахь бохир усны бөглөрөлтөөс урьдчилан сэргийлнэ. Энэ үйл ажиллагаа нь мөн векторын үржлийг зогсооно.</li> </ul>	ЗАА	Барилгыг хүлээлгэн өгсний дараа		
Усан хангамж (усны чанарын асуудал)	<p>Төсөл хэрэгжиж буй байршлуудад усан хангамжийн чанар нь БОАЖЯ-наас тогтоосон стандартыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>Усан хангамжийг бохирдуулахгүйн тулд байнгын хяналтыг тавина.</li> <li>Усан хангамжийг тасралтгүй хлоржуулах ба хлорын үлдэгдэл хэмжээг 0.5 мг/л байлгана.</li> <li>Ус түгээх системийг зүй зохистой хэрэглэнэ (хамгаалах, засварлах)</li> </ul>	УСУГ	Барилгыг хүлээлгэн өгсний дараа		

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
Замын хөдөлгөөн ба ослын аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> <li>Хурдны хязгаар гэх мэт замын хөдөлгөөний хяналтын арга хэмжээг чанд мөрдөнө.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгыг хүлээлгэн өгсний дараа		
Ариун цэвэр	<ul style="list-style-type: none"> <li>Ариун цэвэртэй холбоотой асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар хүмүүст мэдлэг олгох зорилгоор үе үе эрүүл мэнд, эрүүл ахуйн боловсрол олгох / мэдлэг олгох хөтөлбөрүүдийг тогтмол зохион байгуулна.</li> </ul>	НЗДТГ	Барилгыг хүлээлгэн өгсний дараа		
Ойжуулалт	<ul style="list-style-type: none"> <li>Үе үе мод ургамлыг усалж, хогийн ургамлыг цэвэрлэнэ.</li> <li>Үхсэн модыг аль болох хурдан солино.</li> </ul>	ЗАА	Барилгыг хүлээлгэн өгсний дараа		
Агаар бас дуу чимээний чанар	<ul style="list-style-type: none"> <li>Агаар, дуу чимээний чанарыг хяналтын төлөвлөгөөний дагуу хянаана.</li> </ul>	Нийслэлийн авто замын газар	Барилгыг хүлээлгэн өгсний дараа		

### Хүснэгт 1.2 Ногоон байгууламжийн байгаль орны менежментын төлөвлөгөө

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
<b>Р-1 : Барилгын ажлын өмнөх үе шат</b>					
Ногоон байгууламжийн байршлын газар өмчлөл	<ul style="list-style-type: none"> <li>ТХН-ийн Инженер нь дүүрэг, орон нутгийн удирдлагуудтай хамтран ногоон байгууламжийн үйл ажиллагаа явуулах байршлыг шалгаж, төрийн байгууллагын өмчлөлд байгааг баталгаажуулна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажил эхлэхээс өмнө	ТХН/Инженер	ТХН/Инженер
<b>С-1 : Барилгын ажлын үе шат</b>					
Пестицидийн хэрэглээ	<ul style="list-style-type: none"> <li>Ашиглахгүй. Пестицид хэрэглэхийг хатуу хориглоно (гүйцэтгэгчийн тендерийн баримт бичигт тусгана).</li> </ul>				

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
Иргэдэд мэдэгдэх	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь дүүрэг, орон нутгийн удирдлагуудтай уулзана. Томоохон ажлуудыг хэрэгжүүлэхээс өмнө хөрш зэргэлдээх байгууллагуудад мэдэгдэнэ.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Дуу чимээний бохирдол	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын ажил (тарилт орохгүй) өдрийн цагаар хийгдэх бөгөөд өглөөний 07:00 цагаас өмнө, оройны 23:00 цагаас хойш хийгдэхгүй.</li> <li>Ихэвчлэн Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ажиллагаануудын дуу чимээ, чичиргээг хэмждэггүй. Барилгын ажлын явцад хөдөлгүүр, тээврийн хэрэгслээс гарах дуу чимээ нь хязгаарлагдмал бөгөөд их хэмжээний томоохон барилгын ажил хийгддэггүй зэргээс шалтгаалан гаргах дуу чимээ нь ач холбогдол багатай гэж үздэг. Тээврийн хэрэгслийн дуу чимээ, чичиргээний талаар Монгол Улсын стандарт байхгүй тул автомашин, тоног төхөөрөмжийг ашиглахдаа үндэсний MNS 4585: 2007 агаарын чанарын стандартыг мөрдөнө. (Өдрийн цагаар 60 дБА (өглөөний 7:00 - 23:00 цаг [А хэмжээсээр хэмжигддэг])</li> </ul>		Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Гэнэтийн олдвор	<ul style="list-style-type: none"> <li>Археологи, палентолги, соёлын эд өлгийн зүйл талбайгаас олдох тохиолдолд нэн даруй ажлыг зогсоож олдворын хэсгийг хашиж хамгаалж “Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар”-т мэдэгдэнэ. Мөн дээрх тохиолдолд дараах арга хэмжээг авна:</li> <li>Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар нь тухайн газар олдворын талаар Шинжлэх ухааны академи, Палеонтологийн лаборатори болон музей, Археологийн хүрээлэн, Түүхийн хүрээлэнгийнхэнд нэн даруй мэдэгдэнэ.</li> <li>Олдвор болон эргэн тойрон дахль газрын тэмдэглэж, зураг дарна.</li> <li>ШУА-ийн мэргэжилтнүүдийн зөвлөмжийг үндэслэн зааврын дагуу олдворыг ухаж гаргана.</li> <li>Тухайн олдвор нь археологийн ач холбогдол багатай болох албан ёсны мэдэгдэл хүлээн авсны дараа л Гүйцэтгэгч нь барилгын ажлыг үргэлжлүүлж болно. Чухал ач холбогдол бүхий аливаа зүйлийг устгасан эсвэл гаргаж авсан ажилтныг ажлаас нь халах бөгөөд адил хэрэг үйлдсэн бусад этгээдийг Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх болно.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
Иргэд, явган зорчигчдын аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> <li>Замаар зорчих явган зорчигчдод үзэгдэхүйц байрлалд барилгын ажил болон 50см-ээс дээш гүнд хийгдэж буй малтлагын талаар тэмдэг, таниулах самбар байрлуулна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
<b>О-1 : Ашиглалтын үе</b>					
Пестицидийн хэрэглээ	<ul style="list-style-type: none"> <li>Ашиглахгүй. Пестицид хэрэглэхийг хатуу хориглоно (гүйцэтгэгчийн тендерийн баримт бичигт тусгана).</li> </ul>				
Химийн бордооны хэрэглээ	<ul style="list-style-type: none"> <li>Химийн бордоог орлох байгалийн бордоог ашиглана. Зарчмын хувьд химийн бордоо хэрэглэх нь санал болгож буй ботаникийн аргачлалд нийцэхгүй.</li> </ul>	Нийслэлийн байгаль орчны газар	Барилгыг хүлээлгэн өгсний дараа		
Ногоон болон ердийн хатуу хаягдал	<ul style="list-style-type: none"> <li>Зочдын хэрэгцээнд зориулсан хогийн савуудыг байрлуулах болно. Хариуцагч байгууллага нь ногоон хог хаягдлыг цуглуулна. Талбай дээр цугларсан бүх хатуу хог хаягдлыг зохих хогийн цэг рүү тээвэрлэх, эсвэл талбайнаас өөр байршилд дахин боловсрууна (органик хог хаягдлыг бордоо болгох).</li> </ul>	Тохижилт үйлчилгээний газрууд	Барилгыг хүлээлгэн өгсний дараа		

**Хүснэгт 1.3 Газрын гүнийн дулааны системийн суурилалтын байгаль орны менежментын төлөвлөгөө**

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
<b>Р-1 : Барилгын ажлын өмнөх үе шат</b>					
Холбогдох оролцогчдын уялдаа	<ul style="list-style-type: none"> <li>Авч үлдэх, нүүлгэн шилжүүлэх эд зүйлсийг цэцэрлэг, сургуулийн захиралтай зөвлөлдөж тодорхойлно.</li> <li>Тухайн цэцэрлэг, сургуулийн байршилд хийгдэх аливаа ажлыг эхлэхээс өмнө захиралаас нь зөвшөөрөл авна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажил эхлэхээс өмнө	ТХН/Инженер	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
Зочид, ажилчдын аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> <li>Хажуугаар өнгөрөх хүмүүс, мал, амьтаныг ажлын талбарт нэвтрэхээс хамгаалахын тулд хаалт, хашаа, гэрэл болон бусад хамгаалалтыг хийнэ.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажил эхлэхээс өмнө	ТХН/Инженер	ТХН/Инженер
Хэрэгслийн хамгаалалт	<ul style="list-style-type: none"> <li>Барилга угсралтын ажил эхлэхээс өмнө газар доорхи инженерийн шугам сүлжээ, ус зайлуулах хоолой, усалгааны системийг зохих аж ахуйн нэгж, Гүйцэтгэгчийн төлөөлөгчтэй хамтран тогтоож, тэмдэглэнэ.</li> <li>Дамжуулах хоолой болон инженерийн шугам сүлжээг таслах, түр холболт хийхдээ газрын гүний дулааны насосны шинэ системтэй уялдуулан зохицуулна.</li> <li>Өөрийн урсгалаар урсах дамжуулах хоолойн төгсгөлийг стандартад нийцсэн таглаагаар бөглөнө.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажил эхлэхээс өмнө	ТХН/Инженер	ТХН/Инженер
<b>М-1: Гүйцэтгэгчийг талбайд байршуулах ба талбайн цэвэрлэгээ</b>					
Талбайн цэвэрлэгээ	<ul style="list-style-type: none"> <li>Талбайн цэвэрлэгээний үеэр нийтийн болон хувийн эд хөрөнгө эвдэж гэмтэхгүй байх талаар анхаарч бүх шаардлагатай алхамуудыг хийнэ.</li> <li>Хэрвээ ийм хохирол гарвал, эдгээрээс үүсэх үр дагаварыг гүйцэтгэгч бүрэн хариуцна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажил эхлэхээс өмнө	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Ажиллагсдын барилгын талбайн түр байршил	<ul style="list-style-type: none"> <li>Талбайн түр байрыг оршин суугчдын амьдрах орчноос 500м-ээс багагүй зайд байрлуулна.</li> <li>Түр байр, туслах байгууламжийг инженерийн баталсан стандарт, хэмжээсийн дагуу барьж, ашиглана.</li> <li>Асфальтын ба бутлуурын үйлдвэр, материал холих газруудын ойролцоо бие засах газар, жорлонгуудыг байгуулна.</li> <li>Талбайн түр байрын хашаанд хогийн савуудыг байрлуулан тогтмол хоосолж хогийг инженерийн шаардлагыг хангахуйцаар эрүүл ахуйн шаардлага хангасан байдлаар зайлуулна.</li> <li>Барилгын түр байр, үйлдвэрийн газруудад уснаас үүдэлтэй өвчин гарахаас сэргийлэх үүднээс хангалттай хэжээний сайн чанарын усыг нөөцлөн хадгалж, ажилчдын эрүүл мэнд, ариун цэврийн талаар анхаарна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажил эхлэхээс өмнө	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
	<ul style="list-style-type: none"> <li>Газрын хөрс, усны эх үүсвэр, худаг зэргийг бохирдуулахгүй байх үүднээс барилгын ажилчдын түр байранд бохир зайлуулах системийг (бохирын сав, бохир усны нүх г.м.) төлөвлөж, байгуулж, ашиглана.</li> </ul>				
Усны хангамжийн зохицуулалт	<ul style="list-style-type: none"> <li>Усны хүртээмж, ойр орчмын оршин суугчдын хангамжид нөлөөлөхгүй байхаар барилгын ажлын усны шаардлагыг бие даасан байдлаар зохицуулна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажил эхлэхээс өмнө	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Бохирын цэгүүдийг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> <li>Инженер нь дараах зүйлсүүдийг баталгаажуулж, бохирын цэгүүдийн байршлыг эцэслэн тогтооно: (а) Байршил нь ойн бүсэд оршихгүй, (б) Бохир нь байгалийн усны урсацад нөлөөлөхгүй, (в) Бохир нь ховордсон/ховор ургамалд нөлөөлөхгүй,</li> <li>(г) Байршил нь суурин газруудаас 500м-ээс багагүй зайд байрлана.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажил эхлэхээс өмнө	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Гал гарсан үед авах хариу арга хэмжээний бэлтгэл	<p>Гал гарсан үед авах хариу арга хэмжээний бэлтгэлд дараах зүйлс орно:</p> <ul style="list-style-type: none"> <li>Гал түймэр унтраах зориулалттай тоног төхөөрөмжийг ажлын байран дахь гал түймрээс урьдчилан сэргийлэх дүрмийн шаардлагын дагуу барилгын талбар дээр хадгална.</li> <li>Гал түймэр унтраах тоног төхөөрөмж нь стандартын шаардлагыг хангаж байх бөгөөд барилгын ажлын бүх үе шатны турш сайтар шалгана.</li> <li>Шаардлагатай үед, ажлын байранд гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор барилгын хүнд болон хөнгөн машин механизм, усны машин, тээврийн хэрэгслийг гал унтраах хэрэгслийн хамт (жишээлбэл, усны цүнх, тармуурын зээтүү, гал унтраагч гэх мэт) бэлэн байлгана.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажил эхлэхээс өмнө	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
<b>С-1: Барилгын ажлын үе шат</b>					
Ариун цэвэр ба эрүүл ахуйн асуудал	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын талбайг цэвэр, тохилог нөхцөлд байлгана. Бүх гарсан хог, хаягдлыг сайтар цэвэрлэнэ.</li> <li>Хүн, амьтны эрүүл мэнд болон ургамал зэрэгт хортой, тэднийг гэмтээх магадлалтай хориотой материалыг ашиглах, тэдгээрийг үйлдвэрлэх зэргийг үл зөвшөөрнө. Хэрвээ тийм материалаас</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер



Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
	зайлсхийх боломжгүй бол ажилчдыг хамгаалалтын хувцас хэрэгслээр хангана.				
Газрын тогворжилт болон байр зүй	<ul style="list-style-type: none"> <li>Газар шрооны ажлыг БНБД 50-02-07 “Барилгын газар шороо ба буурь, сүүрийн ажил”-ын дагуу хийж гүйцэтгэнэ.</li> <li>Ургамлын хөрсийг хуулан авч өрөмдлөг хийж буй орчинд саад болохооргүй газар хадгална.</li> <li>Сул болон суларсан хөрс үхсэн нүх рүү унахаас хамгаалж, хамгаалалтын хайс хашлага хийнэ.</li> <li>Буцааж булаах ажлын хөрсний чийгшил нягтралыг харьцаа нь MNS стандартад нийцсэн эсэхийг бие даасан хөндлөнгийн байгууллагын лабораторын туршилтаар хэмжиж баталгаажуулна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Барилга байгууламжийн тогтвортой байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> <li>Хамгаалалтын тулгуур, хайс хашлага хийгдээгүй тохиолдолд барилга байгууламжийн эргэн тойронд болон доогуур үхалт хийхийг хориглоно.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Усны чанар	<ul style="list-style-type: none"> <li>Өрөмдлөгөөс гарсан хаягдал ус, насосны туршилт болон бусад үйл ажиллагааны явцад бий болсон ус нь барилга байгууламж, зам, шугам сүлжээ болон бусад барилгын талбайд орж, эвдрэл гэмтэл учруулахаас сэргийлэх арга хэмжээг авах хэрэгтэй. Өрөмдлөгөөс гарсан бохир ус, шавар шалбаагнаас үүдэлтэй гэмтэл хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.</li> <li>Гүйцэтгэгч нь хог хаягдал, усны менежмент, ус бохирдохоос хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг гарган ажиллана.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Элэгдэл	<ul style="list-style-type: none"> <li>Гүйцэтгэгч нь барилгын талбайд ус алдалтаас сэргийлсэн усны хяналтын арга хэмжээ болон хөрсний элэгдэл, тунгаагуур үүсэхээс хамгаалсан хөрс тогтворжуулах арга хэмжээг тус тус төлөвлөн ажиллана.</li> <li>Барилгын талбайд гадаргуугийн элэгдлээс хамгаалах материал байршуулна.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
	<ul style="list-style-type: none"> <li>Геосүлжмэл (Geotextile fabric) хуудсыг газрын гадаргуун доор ус шүүрүүлийн системд филтер/ тусгаарлагч болгон ашигладаг. Геосүлжмэл нь хайрга болон шаварлаг хөрснүүдийг тусгаарлан, усыг гадагшлуулж, хөрсийг тогторжуулах үүрэгтэй.</li> </ul>				
Хөрсний бохирдол	<ul style="list-style-type: none"> <li>Газрын гүний дулааны системийн өрөмдлөгийн үед усны үет давхаргыг тусгай зориулалтын зуурмагаар бөглөж бохирдохоос хамгаална. Энэхүү чигжээсний зуурмаг нь уян хатан /урсамтгай/ байх шаардлагатай. Жнь: бентонитын төрлийн материал байж болно.</li> <li>Чигжээсний материалын дулаан болон гидравлик дамжуулалтын шинж чанарыг хөндлөнгийн лабораториор шалгуулж, стандартад нийцэж байгаа эсхийг шалгуулах шаардлагатай. Уст үеийн чигжээст ашиглахын өмнөх зуурмагийн материал нь шавар агуулаагүй, органик байх шаардлагатай.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Агаарын чанар	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын тоног төхөөрөмж, машин механизмаас ялгарах хорт утааг тогтоосон стандартад нийцүүлэн ашиглана.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Дуу чимээ	<ul style="list-style-type: none"> <li>Гүйцэтгэгч нь хэт их чимээ шуугианаас урьдчилан сэргийлэх, дуу чимээг хянах, бууруулах талаархи холбогдох үндэсний хууль тогтоомж, дүрмийг дагаж мөрдөнө. (БНБД 23-05-10, Дуу тусгаарлагч)</li> <li>Хүн амын суурин газраас 150м -ийн зайд байрлах барилгын талбайд оройн 22:00 цагаас өглөөний 6:00 цагийн хооронд дуу чимээ ихтэй барилга үйл ажиллагаа зогсооно</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер
Өрөмдлөг	<ul style="list-style-type: none"> <li>Ажил эхлэх зөвшөөрлийг Нийслэлийн холбогдох байгууллагаас авах шаардлагатай.</li> <li>Өрөмдлөгийн машин механизм нь дуу чимээнд тавигдах стандартын шаардлагыг хангасан байна.</li> <li>Өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулж байгаа ажлын талбайг усаар шүршин чийгшүүлж, агаарын чанарын стандартад нийцүүлэх шаардлагатай.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
Барилгын ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй	<ul style="list-style-type: none"> <li>Зам, явган хүний зам, далан суваг, ус хангамжийн шугам сүлжээг барьж байгуулахад хог хаягдал зайлшгүй гарна. Гэхдээ жирийн нөхцөлд хогийн хэмжээ харьцангуй бага байна. Харин зам/явган хүний зам барих үед хөрс хуулж зайлуулах учраас гарах хогийн хэмжээ жирийн үеийнхээс их байна.</li> <li>Гүйцэтгэгч нь барилгын талбайд хяналт тавьж, түүнийг цэвэр цэмцгэр байлгах, гарч байгаа хогийн зайлуулах хүртэл хогийг байр саванд түр хадгалах ажлыг хариуцна.</li> <li>Барилгын хог хаягдлыг тусгай хогийн талбайд хадгална. Ийм хогийг хадгалахдаа ус хангамж, усны эх үүсвэрийг бохирдохоос хамгаалж, мөн хуурай улиралд шороо тоос босохоос хамгаалах арга хэмжээ авна.</li> <li>Гүйцэтгэгч нь байгаль орчныг бохирдуулах, хүн, амьтанд хортой нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх үүднээс бүх хогийг болгоомжтой тээвэрлэх, хадгалах үүргийг хүлээнэ.</li> <li>Барилгын талбайд ажиллах бүх хүмүүсийн хөдөлмөр хамгаалал, ая тухтай байдал, эрүүл мэндийг баталгаажуулах, аюулгүй орчинд үр дүнтэй ажиллах нөхцөл хангахад шаардлагатай урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авна.</li> <li>Барилгын талбайд аюултай байрлалд ажиллаж байгаа ажилчид хамгаалалтын малгай, зориулалтын гутал өмсөнө. Барилгын талбайд ажиллаж байгаа бүх ажилчид нь нүдний хамгаалалтын шил, сонсголын хамгаалалт, хамгаалалтын малгай зэрэг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл өмсөнө.</li> <li>Гал унтраагч болон анхны тусламжийн төхөөрөмжүүдийг барилгын талбайд байлгана.</li> <li>Барилгын талбайд бэртэл гэмтэл гарч болзошгүй. Иймээс барилгын бүх ажилчдад зориулсан эмнэлгийн анхны тусламжийн хэрэгслийг заавал байлгана.</li> <li>Гүйцэтгэгч нь угсралтын бүх ажилд зөвхөн мэргэшсэн, чадварлаг ажилчдыг ашиглана.</li> </ul>	Төсөл хэрэгжүүлэх талбар	Барилгын ажлын явцад	Гүйцэтгэгч	ТХН/Инженер

Байгаль орчны нөлөө/асуудлууд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	Байршил	Хугацаа	Үүрэг хариуцлага	
				Хэрэгжүүлэлт	Хяналт
	<ul style="list-style-type: none"> <li>• Санамсаргүй гэмтлээс үүдэх онцгой нөхцөл байдлыг илрүүлэх/шийдвэрлэх талаар ажилтнуудад сургалт явуулна.</li> <li>• Аюулгүй ажиллагааны арга хэмжээ, ажлын горимыг газар дээр нь хэрэгжүүлнэ. Ажилчид аюултай нөхцөлд ажиллахаас татгалзах эрхтэй болно.</li> <li>• Гүйцэтгэгч нь осол аваараас урьдчилан сэргийлэх үүднээс ажлын байран дахь аюулгүй ажиллагааны журмыг боловсруулж, мөрдүүлэх ёстой.</li> <li>• Гүйцэтгэгч нь ХАБ-ын үйл ажиллагааны стандарт, зааврыг боловсруулж мөрдүүлнэ.</li> <li>• Гүйцэтгэгч нь ажилчдад эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар мэдлэг мэдээлэл олгоно.</li> <li>• Гүйцэтгэгч нь ажилтнуудад гал түймэр/тэсэлгээний үед авах арга хэмжээний талаар сургалт явуулна.</li> <li>• Гүйцэтгэгч нь ажилчдыг гэмтээхээс урьдчилан сэргийлэхийн тулд барилгын бүх тоног төхөөрөмжийг аюулгүй ажиллагааны нөхцөлд байлгана.</li> </ul>				

